



ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 02/24

Жаргалант сум

Ногоон Жаргалант хөтөлбөрийг шинэчлэн  
батлах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны  
арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ногоон Жаргалант хөтөлбөрийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

6125010073

143  
Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны  
09/24 тогтоолын нэгдүгээр хавсралт

## “НОГООН ЖАРГАЛАНТ” ХӨТӨЛБӨР

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Жаргалант сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд зорилго зорилтуудаа дэвшүүлээ.

### ХОЁР.ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2025 оны байдлаар Жаргалант сумын нийт ойн сан 16.3 мянган га талбайг хамарч байна. Суурьшлын бүсэд нийт 3,2 га талбай бүхий ногоон байгууламжтай. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Жаргалант сумын хэмжээнд 10 жилийн хугацаанд 11 сая мод тарихаар төлөвлөгдсөн.

Жаргалант сумын хэмжээнд жилд дунджаар 3200 шоо метр энгийн хатуу хог хаягдал үүсдэг. Орон сууцны хороолол дунд хог түр хадгалах зориулалт бүхий 3 пункер, гэр хорооллын 70 өрхөд хог ангилан ялгах төмөр хийцийн сав байрлуулсан ба бусад өрх, аж ахуйн нэгж байгууллагыг эх үүсвэр дээр нь ачиж тээвэрлэж байна.

2017 оноос хойш хаягдлыг тээвэрлэх парк шинэчлэл, төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн сэргээх, хог хаягдал түр хадгалах сав суурилуулах, ногоон байгууламжийн хашлагыг шинэчлэх, суурьшлын бүсэд мод тарих гэх мэт томоохон үйл ажиллагааг дэс дараатайгаар зохион байгуулсан.

### ГУРАВ.ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Сумын хэмжээнд хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахивар хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлэх систем байхгүй ба шаардлагатай менежмент шинэчлэл хийгээгүй тохиолдолд төвлөрсөн хогийн цэгийг 2027 оноос эхлэн үргэлжлүүлэн ашиглахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, хамгаалалтын ойн зурвасыг шинээр байгуулахаас гадна өрхийн хэрэгцээний газарт мод тарих ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Сумын хэмжээнд газрын өнгөний ус ашигладаг өрхүүдийн хувьд хөрсний бохирдол, усны чанарт хийгдсэн нэгдсэн судалгааны бааз байхгүй байгаатай холбогдуулан тэдгээрийг шинжилгээнд хамруулж мөн хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор суурьшлын бүсийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эзэнгүй нохой устгах ажлыг жил бүр зохион байгуулдаг боловч механикаар цөөрүүлэх ажил нь амьтны өөрийн үржлийн прогрессыг давж чаддаггүй тул тоо толгойг цөөрүүлэх биологийн аргыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

## ДӨРӨВ.ХАМРАХ ХҮРЭЭ

- 4.1 Хөтөлбөрт Жаргалант сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана;  
4.2 Жаргалант, Улаантолгой, Дулаан-Уул багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөр хэрэгжинэ;

### ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

#### 5.1.Хөтөлбөрийн зорилго

5.1.1.Байгалийн унаган төрхийг хадгалах, ашиглалтын зөв менежментийг нэвтрүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг хангах;

#### 5.2.Хөтөлбөрийн зорилт

- 5.2.1.Хог хаягдлын менежментийг сайжруулах;  
5.2.2.Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг сайжруулах;  
5.2.3.Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг дэмжих;

### ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭМЖЭЭ

#### 6.1.Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилтын хүрээнд

- 6.1.1.Хог шатаах, боловсруулах технологи нэвтрүүлэх;  
6.1.2.Нийлэг хальсан уутны хэрэглээг багасгаж байгальд ээлтэй хэрэглээг нэвтрүүлэх;  
6.1.3.Эзэнгүй муур нохойн тоо толгойг цөөрүүлэх;  
6.1.4.Төвлөрсөн хогийн цэгийн хэвийн үйл ажиллагааг хангах;  
6.1.5.Эзэнгүй хог хаягдлыг зайлуулах, бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах;  
6.1.6.Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын эзэнгүй хог хаягдлыг бууруулах зорилгоор нүүдлийн мал аж ахуйн эрхэлдэг өрхүүдэд хяналт тавих;

#### 6.2.Ойн санг хамгаалах нөхөн сэргээх, ногоон байгууламжийг сайжруулах;

- 6.2.1.Суурьшлын бүсийн хөрсийг хамгаалах зорилгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нэрэмжит ойн төгөл байгуулах;  
6.2.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтийн мод тарих өдрөөр иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх;  
6.2.3.Гэр бүлийн хэрэгцээний газарт мод, бут, сөөг тарьсан иргэдийг урамшуулах системийг нэвтрүүлэх;  
6.2.4.Ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах;  
6.2.5.Ойн хортон шавжийн тэмцлийн ажлыг зохион байгуулах;  
6.2.6.Ойн хортон шавжийн тархалтын судалгааг зохион байгуулах;  
6.2.7.Тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд үр тарианы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх;

#### 6.3.Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг дэмжих

- 6.3.1.Байгаль хамгаалах арга хэмжээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны багц хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;  
6.3.2.Үйлдвэрийн зориулалтаар ус ашиглагч иргэн аж ахуйн нэгжүүдийн худгийн цооногийг тоолууржуулах;  
6.3.3.Булгийн эхийг хашиж хамгаалах, засварлах;

6.3.4.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж мэдээлэл хүргэх, гал түймэр унтраах багаж, зэвсэглэмжийг шинэчлэн сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах;

6.4.5.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах;

### ДОЛОО.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

7.1.Байгалийн унаган төрхийг хадгалахад иргэдийн идэвх оролцоог ямагт дэмжих;

7.2.Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

7.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрхзүйн хүрээнд явуулах;

### НАЙМ.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2026-2028 он хүртэл 3 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ;

### ЕС.ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1.Хөтөлбөрийг сумын Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн байгууллагууд хамтран гүйцэтгэнэ.

9.2.Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах ба дараа оны төлөвлөгөөг мөн жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

Амгалант / А.А.А. /  
2024.09.10

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны  
02/11 тогтоолын хоёрдугаар хавсралт

2025.12.16

Жаргалант сум

НОГООН ЖАРГАЛАНТ ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Санхүүжилт		Хариуцан хэрэгжүүлэгч
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин (2026 он)	Санхүүжилт мян.төг	Санхүүжилтийн ангилал	
1	Хог хаягдлын менежментийг сайжруулах	Эзэнгүй нохой, муурын тоо толгойг хүмүүнлэг аргаар бууруулах (уржил хаах ажилбар, пайжлуулалт, бичил чип суулгах, тарилгын аргаар унтуулах)	Хамрагдсан нийт бодгалийн тоо(давхардсан тоогоор)	ширхэг	2025	111	311	20,000.0	ОНХС	Багийн ажлын алба, Байгаль орчны хэсэг, эрх бүхий мэргэжлийн байгууллага

2	Эзэнгүй нохой, муурын тоо толгойг уламжлалт аргаар бууруулах (буудах)	Хамрагдсан нийт бодгалын тоо (давхардсан тоогоор)	ширхэг	2025	272	472	8,000.0	ОНХС	Багийн ажлын алба, Байгаль орчны хэсэг, Хот тохижуулах газар
3	Төвлөрсөн хогийн цэг дахь зориулалтын бус газарт төвлөрсөн хог хаягдлыг түрж тэгшлэх	Түрэлт хийгдсэн тоо	Удаа	2025	4	8	8,000.0	ОНХС	Байгаль орчны хэсэг, Нийтлэг үйлчилгээний алба
4	Төвлөрсөн хогийн хогийн цэгийн хог хаягдлыг түрж тэгшлэх	Төвлөрсөн хогийн цэг дахь дарж булшилсан талбайн хэмжээ	га	2025	4	8	20,000.0	ОНХС	Байгаль орчны хэсэг



9	Ахуйн үйлдвэрлэлийн ашиглагчдын тоолууржуулалтад хяналт тавих болон ус	Хамрагдсан ус ашиглагчийн тоо	ш	2025	0	20	532.0	БНАТ	Байгаль орчны хэсэг
10	Хүний дам шууд үйлдлээр ойн санд үзүүлэх хөнөөлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах	Эргүүл хяналт шалгалтын ажлаар туулсан замын хэмжээ	км	2025	7,400	14,800	888.0	БНАТ	Байгаль орчны хэсэг